



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

I-VI/2025

Тархаасан: 2025 оны 7 дугаар сарын 18

Улсын хилээр орсон гадаадын зорчигчид, өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар өсжээ.

Манай улсын хилээр 2025 оны эхний хагас жилд 3 594.7 мянган (давхардсан тоогоор) зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 523.3 (17.0%) мянгаар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧИД

Үзүүлэлт	Жил			Эхний хагас жил			2025 I-VI 2024 I-VI	
	2022	2023	2024	2023 I-VI	2024 I-VI	2025 I-VI	Зөрүү	Хувь
	хүн							
Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид ¹	2 016 206	5 334 855	7 179 128	2 117 653	3 071 367	3 594 685	523 318	17.0
Улсын хилээр орсон зорчигчид ¹	988 595	2 652 893	3 576 555	1 059 115	1 547 281	1 821 158	273 877	17.7
Улсын хилээр гарсан зорчигчид ¹	1 027 611	2 681 962	3 602 573	1 058 538	1 524 086	1 773 527	249 441	16.4
Улсын хилээр орсон жуулчид	286 282	594 013	727 386	226 848	245 787	328 395	82 808	33.6

¹ Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдод гадаадын болон дотоодын иргэдийг хамруулав.

2025 оны эхний хагас жилд 1 821.1 мянган зорчигч улсын хилээр орсны 37.8 хувь нь Замын-Үүд, 26.0 хувь нь Чингис хаан, 8.5 хувь нь Алтанбулаг, 8.2 хувь нь Гашуун сухайт, 5.6 хувь нь Шивээхүрэн, 13.9 хувь нь бусад боомтоор тус тус орсон байна.


Улсын хилээр орсон зорчигчдын 1 442.5 (79.2%) мянга нь Монгол Улсын иргэд, 378.6 (20.8%) мянга нь гадаад улсын иргэд байгаагаас Монгол Улсын иргэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 223.4 (18.3%) мянга, гадаад улсын иргэд 50.4 (15.4%) мянгаар тус тус нэмэгджээ. Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 240.4 (63.5%) мянга нь эрэгтэйчүүд, 138.2 (36.5%) мянга нь эмэгтэйчүүд байна. Гадаад зорчигчдыг насны бүлгээр авч үзвэл 219.7 (58.0%) мянга нь 35-59 насныхан дийлэнх хувийг эзэлж байна. Мөн зорчсон хугацаагаар нь авч үзвэл 52.7 (13.9%) мянга нь 10 хүртэл хоног, 275.5 (72.8%) мянга нь 30 хүртэл хоног, 4.1 (1.1%) мянга нь 60-аас 90 хүртэлх хоног, 46.3 (12.2%) мянга нь 90-ээс дээш хоногоор зорчжээ.

Улсын хилээр орсон гадаадын зорчигчдыг бүс нутгаар нь авч үзвэл 62.3 хувь нь Зүүн Ази, Номхон Далайн бүс нутаг, 32.0 хувь нь Европ, 2.7 хувь нь Америк, 1.6 хувь нь Ойрх Дорнод, 1.2 хувь нь Өмнөд Ази, 0.2 хувь нь Африк тивийн зорчигчид эзэлж байна.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 34.9 хувь нь БНХАУ-ын иргэд, 25.9 хувь нь ОХУ-ын иргэд, 16.0 хувь нь БНСУ-ын улсын иргэд, 3.0 хувь нь Япон улсын иргэд, 2.7 хувь нь Казахстан улсын иргэд, 17.5 хувийг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.

ЗУРАГ 1.

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААД ЗОРЧИГЧИД, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2024, 2025 он




Улсын хилээр орсон жуулчдыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, БНХАУ-ын жуулчид 34.8 (58.9%) мянга, БНСУ-ын жуулчид 13.2 (28.6%)

мянга, ОХУ-ын жуулчид, 7.4 (8.4%) мянга, Япон улсын жуулчид 4.5 (69.6%) мянга, Казахстан улсын жуулчид 0.3 (3.7%) мянгаар тус тус өсжээ.

ЗУРАГ 2.

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ЖУУЛЧИД, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Манай улсаас гадаад улсад зорчсон иргэд 2025 оны эхний хагас жилд 1 423.1 (давхардсан тоогоор) мянга болж өмнөх оны мөн үеэс 201.0 (16.4%) мянган хүнээр өсөхөд БНХАУ руу зорчсон иргэдийн тоо 174.9 (19.8%), Япон руу 6.4 (30.8%) мянгаар нэмэгдсэн бол ОХУ руу 5.5 (3.7%), БНСУ руу 4.5 (5.2%) мянган хүнээр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.



Гадаадад зорчсон Монгол Улсын иргэдийн 873.5 (61.4%) мянга нь эрэгтэйчүүд, 549.6 (38.6%) мянга нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр нь

авч үзвэл 30-54 насныхан 926.3 (65.1%) мянга нь дийлэнх хувийг эзэлж байна. Тэдний 40.6 (2.9%) мянга нь 10 хүртэл хоног, 1 328.0 (93.3%) мянга нь 30 хүртэл хоног, 7.6 (0.5%) мянга нь 60-аас 90 хүртэл хоног, 46.9 (3.3%) мянга нь 90-с дээш хоноогоор гадаадад зорчжээ.

Энэ оны эхний хагас жилд гадаадад зорчсон Монгол иргэдийн 41.0 (2.9%) мянга нь албан/бизнесийн, 1 382.1 (97.1%) мянга нь хувийн зорилгоор зорчсон байна.

ЗУРАГ 3.

ГАДААДАД ЗОРЧСОН МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, зорчсон улсаар, дүнд эзлэх хувиар, 2024, 2025 он




Улсын хилээр 2025 оны эхний хагас жилд (давхардсан тоогоор) 1 679.0 мянган тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 61.1 (3.8%) мянгаар өсжээ. Тэдгээрийн 46.0 хувийг ачааны машин, 29.0 хувийг ачааны вагон, 21.9 хувийг суудлын машин, 3.1 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Нийт тээврийн хэрэгслийн 45.3 хувь нь Замын-Үүд, 16.0 хувь нь Гашуун сухайт, 10.6 хувь нь Шивээхүрэн, 7.1 хувь нь Алтанбулаг, 21.0 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрчээ.

ЗУРАГ 4.

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, боомтын төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2024, 2025 он



Ойлголт, тодорхойлолт:

Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдод гадаадын болон дотоодын иргэдийг хамруулав. Монгол Улсын хилээр орсон зорчигчдыг зорилгоор нь албаны, хувийн гэж ангилна. Хувийн зорилгыг дотор нь аялал жуулчлал баяр ёслолд оролцох, амралт зугаалгаар аялах, найз нөхөд хамаатныдаа зочлох, эмчилгээ, шашин мөргөл, суралцах, хөдөлмөр эрхлэх, байнга оршин суух, соёл, урлаг, спорт, дамжин өнгөрөх, худалдаа хийх бусад гэж ангилна.

Жуулчин: Өөрийн байнга оршин суудаг газар нутгаас өөр газарт 90 хоног хүртэлх хугацаагаар байнга оршин суух, суралцах, ажил хөдөлмөр эрхлэхээс бусад зорилгоор аялал жуулчлалд хамрагдаж байгаа хүнийг ойлгоно.



Эх үүсвэр:

Хил хамгаалах ерөнхий газар

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 10 дугаар сарын 16

Мэдээлэл авах холбоос:

<http://www.1212.mn/>

Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын
дарга Ш.Ариунболд
Утас : (+976) 51-261523

Тооллого, өгөгдлийн шинжилгээний
газрын Хүн ам, орон сууцны тооллогын
хэлтсийн ахлах мэргэжилтэн З.Сайнзаяа
Утас : (+976) 51-267547



/StatisticMGL



information@nso.mn



7014-1212